

БАГШ ШАВИЙН УЛАМЖЛАЛТ ХАРИЛЦАА

Г.Сэр-од

Их Монгол дээд сургууль.

Өгүүллийн товч утга: Монголын боловсролын түүхийн нэгэн чухал судлагдахуун бол багш шавийн харилцаа юм. Энэхүү эрхэм барилдлага нь Төв Азийн анхны төрт улс Хүннү нараас улбаалж, Монголын эзэнт гүрэнээр дамжин өнөө үеийг хүртэл улам баяжигдан хөгжсөөр, хойшид ч улам бадамлах болно.

Түлхүүр үг: Багш шавийн харилцаа, багшийг хүндэтгэх ёсон, улсын багш, ёс суртахуун.

Монголчуудын хүнийг үзэх үзэл нь эрхэм бөлгөө. Монгол хүн бусдыг шинжин таних талаар манлай, хүн судлалын бурхад хэмээлтэй. Ялангуяа хойч үе, үр хүүхдээ сурган хүмүүжүүлэх, сайн хүн болгож, хүнээр хүн бүтээх талаар ардын далай мэт гүн, тэнгэр адил хязгааргүй туршлагыг хуримтлуулжээ. Энэхүү хүн бүтээх авъяас билэг, оюун ухаан төгөлдөр урлаач бол *багш* болой. Түүний уран бүтээлийг *шавь* хэмээмуй. Багш гэгч чухам хэн бэ?, багшийн хөдөлмөрийн талаар эн хорвоогийн хамгийн нандин мэргэжил багш хүнд заяажээ, шавийн эрдэм багшаас зэрэг олон сайхан үг байдаг. Мөн яруу найрагт ч багшийн алдарыг өгүүлжээ.

Багш та хормой өвдөгнөөс нь адис авмаар хүмүүн бурхан

Багш та хоёр үгнээс нь арван эрдэм цацардаг гүн ухаан

Багш та хорвоог гийгүүлэхээр тэнгэрт ургасан өглөөний наран

Багш та хойчын тусын тулд ирээдүйгээс ирсэн хүмүүн бурхан гэжээ. ХҮI үед монголын өмнөд нутгаар аялан явсан нэгэн Хятад жуулчины тэмдэглэлд: "Бичиг үсэглэж чадах хүнээ **багш** гэнэ. Энэ нь **сурагч** болой. Шавь нь багшийг дагаж бичиг ном үзэж эхлэхдээ хонь, архиар бэлэг барьж мөргөнө. ... Бичиг ном үзэж сурсан хойно багшдаа эрхбиш нэг саарал морь, нэг цагаан хувцас өгч талархана..." /1/ хэмээсэн байдаг байна. Бид энэ бяцхан өгүүлэлдээ тэрхүү гайхамшигт уран бүтээлчийн болон түүний бүтээл хоорондын харилцааны талаар товч дурьдахыг оролдсон амой.

Багш, шавийн харилцааны түүхэн тойм:

Хүн төрөлхтөний сурган хүмүүжүүлэх уламжлал нь хүнийг төлөвшүүлэх өөрөөр хэлбэл байгалийн хүнийг нийгмийн хүн болгон хөгжүүлэх үзэл санаа, туршлага болон хөгжиж ирсэн жамтай ажээ. Үүний адилаар монголчуудын сурган хүмүүжүүлэх сэтгэлгээ тэр дундаа *багш шавийн уламжлал* нь ч мөн эрт цагаас улбаатайг судлаачид тогтоожээ.

Тухайлбал: эртний ураг төрлийн байгуулалын үед багш шавийн харилцаа нь овгийн ахлагч болон гишүүдийн харилцаагаар илэрч байжээ. *Овгийн ахлагч болон тухайн овгийн хамгийн ахмад, амьдралын баялаг туршлагатай бууралууд гишүүд /үр ач, хойч үе/-дээ удам угсаагаа уламжлан үлдээх, хүн хүнээ хайрлах хүндэтгэх ёсонд замчлан оруулдаг байв* /2/. Чухамхүү энэ үеэс нэг нь заадаг /заалгадаг/, сургадаг /сурдаг/ нөгөө хэсэг нь түүнийг сайтар соёолуулан ургуулах үйл хэрэгт хувь заяагаа нэгтгэдэг байна. Үүнийг сурган хүмүүжүүлэх ухааны үүднээс хамгийн товчоор **багш, шавийн харилцааны бүдүүлэг илрэлийн хэлбэр** хэмээж болох юм. Хожим тэд дан ганц ёс суртахууны замаар замнасангүй.

Овог дотор нийгмийн ялгарал гүнзгийрч, нийгэм соёлын орон зайн тэлэлтэнд өртөж, нум сум харвах ан авлахаас эхлээд дайн тулааны наад захын эрдэм чадварт хэн нэг /жишээ нь эцэг нь хүүгээ дагуулан нум сум харвах болон

ан ав хийхийг заах, тулаанд гарамгай нь бусаддаа өөрийн арга барилаа эзэмшүүлэх г.м/-ний оролцоотойгоор улам гүн чадвар эзэмших болжээ. Үүнийг эзэмшихэд хэн нэг хүн засан залруулж байсан нь дамжиггүй юм.

Монголын нутаг дээр ноёрхож байсан эртний улсуудын үед дурьдан буй асуудал мэргэжилийн тал руу нилээд гүнзгий орсон байжээ. Манай нэрт судлаач Г.Сүхбаатар Сүмбэ улсын үед Сүмбэ хэлний холбоотой дөрвөн номыг хэлний сурах бичиг хэмээн үзэж, энэ хэлийг тусгайлан зааж байсан /3/ хэмээн үзжээ. Мөн тэрээр цааш нь өгүүлэхдээ *"Их Вей улсын ноёрхолын цагт түшмэд мэтийн албан тушаалтаныг бэлтгэх сургууль байгуулж, таван ухаанд мэргэшсэн бичгийн их хүн /багш Г.С./-ийг тавьж, төрийн хүүхдүүдийн сурагчийн тоог гурван мянгаар нэмэгдүүлсэн"* /4/ хэмээн "Вей улсын түүх"-нд өгүүлсэнийг онцлон тэмдэглэжээ. Энэ мөн нэгийг өгүүлэх буюу.

Түрэг, Уйгар улсуудын үед багш шавийн харилцаа улам өргөжсөн бололтой байна. Үүний том нотолгоо бол Монгол Улсын нутаг дахь Орхон голын саваар төвлөрсөн эртний Түрэг хэлний дурсгал буюу Орхоны соёл, Сүүжийн хад, Сэлэнгийн чулууны бичээс юм /5/. Эртний Түрэг хэлний эдгээр арвин дурсгалууд нь тухайн үндэстэний дотор хэлээ сайн мэддэг чадвартан байсныг гэрчлэх төдийгүй өөрийн мэддэг зүйлээ бусаддаа заан сургадаг байсан нь гарцаагүй юм. Мөн ҮШ-Х зууны үеийн Хятан нар 920 онд зохиосон *"Их бичиг /зураг бичиг/"*, Х зууны сүүлчээр зохиосон *"Бага бичиг /уйгар бичигт тулгуурласан/"* зэргийг зохион хэрэглэж байснаас гадна төмөр хайлуулах, цутгах, сав суулга хийх мэдлэг ухаан хөгжиж байсан /6/ зэрэг нь эцэг өвгөд нь хойч үедээ өөрсдийн соёл, боловсролоо сурган өвлүүлдэг болох нь тодорхой болой.

Монголын эзэнт гүрний үед *багш шавийн харилцаа* нь төрийн бодлогын нэгэн чухал хэсэг болсон байна. Чингис хаан болон түүний залгамжлагч Монголын хаадууд өөрийнхөө дэргэд бичиг, цэргийн эрдэмд нэвтэрсэн чадвартаныг дэргэдээ авч ажилуулж байв. Мөн эрдэм мэдлэгтэй хүмүүсийг өөрийн үр ач нартаа бичиг үсэг, эрдэм ном заалгадаг байв. Үүнтэй холбогдуулан хэдэн баримт дурьдъя. Чингис хаан Найман аймгийг буулган авч байх үест дүү Хасар нь Таян хааны тамгачыг олзлон авч хаан ахдаа тушаажээ. Түүний нэрийг Тататунгаа хэмээнэ. Чингис хаан Тататунгааг машид үнэлэн өөрийн хөвгүүд, дүү нар болон дээдсийн хүүхдүүдэд бичиг ном заалгахаар урин залж байсан нь Монголын түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн *багш шавийн харилцааны нэгэн шинэ үе* эхэлсэн буюу. Тататунгаа багшийн шавь нар дотор хамгийн ахмад нь дечин насыг зооглон буй их хааны дүү Хасар жанжин байжээ. Энэ талаар сурвалжийн мэдээг сөхвөл: *"Хасар Тататунгааг багш барин бичиг хууль, цэргийн бодлого тэргүүтэн олон зүйлийн бичиг утга заалгаж тун удалгүй сурав"* /7/ хэмээн Мэргэн гэгээний Алтан товч сударт тэмдэглэгдсэн байх ажгуу. Мөн Монголын эзэнт гүрний тавдахь их хаан Хубилай 1260 хаан ширээнд суумагцаа *Түвэдийн нэртэй, номтой лам Пагва Лодойжалцан /1235-1280 он/-г "Улсын багш" өргөмжлөн Монгол гүрний шинэ бичиг /дөрвөлжин үсэг/ зохион /8/ хан хөвгүүд, ард иргэдэд заан сургахыг чухалчилж байжээ.* Мөн XIII зууны Монголын бичгийн их хүн Чойжи-Одсэр Юань гүрний Өлзийт хааны үе /1295-1307 он/-д *"Улсын багш"-аар өргөмжлөгдөн олон ном судар орчуулж байсан /9/ мэдээ түүхэнд тэмдэглэгдэн үлджээ.* Эдгээр түүхэн баримт нь багш, шавийн харилцаа-багшийг шүтэх ёс нь харц ардаасаа эхлээд төр гүрэн хүртэл эрхэмлэн хүндэтгэж байсны чухам илрэл болно.

Бидний монголчуудын нүүдлийн амьдралд зохицон боловсрогдсон сурган хүмүүжүүлэх сэтгэлгээний онцлог нь манай түүхэнд хар бараанаар бичигдсэн Манж ийн эрхшээлийн цаг үеэс эхлэн дорно дахины болон өрнө дахины Орос мэт харийн хүч түрэн орж ирсэн. Гэсэн хэдий ч уламжлалт зан суртахуунаа алддалгүй ирсэнийг тэмдэглэх чухалтай болно.

XVII зууны эхээр Халхын Цогт хун тайжийн эх Мадэ /зарим зохиолд Чин хэмээсэн буй/ Тайгал хатан хүүхэд, багачууд бичиг ном сурган багшилж байсан мэдээ буй. Түүх шастираас авч хэлбэл, нутаг орондоо ном бичиг суралцсан нэг нь хүүхэд багачуудад гэрээрээ бичиг үсэгт сургадаг байсан нь нэг ёсны бичигдээгүй хууль байжээ.

Ийнхүү багш, шавийн харилцаа нь харийн эрхшээлээс тусгаар улсаа мандуулсан цагаас эхлэн шинэ орон зайг эзлэх болов. XX зууны үеэс сурган хүмүүжүүлэх ухаанд гарсан ахиц дэвшлийг дагалдан багш, шавийн харилцаа нийгэм улс төрийн шинж чанартай болсон. Өөрөөр хэлбэл төр аливаа зүйлд сургадаг хүнийг өөрөө бэлтгээд зогсоогүй түүнд суралцах сурагчийг ч мөн төр засгийн ивээлээр сургадаг болсон. Багш, шавийн харилцаа нь нийгмийн дэвшил, оюуны бойжилтыг даган их мөрөн адил тасралтгүй үргэлжилсээр л байна.

Багшийг хүндэтгэх Монгол уламжлал:

Бидний Монголчууд багш хэмээх манлайн чимэг болсон хүнийг танин болгоох ухааныг бий болгожээ. Багшийг эрхэмлэн хүндэтгэх болсон нь шашин номын ухаан шавилан суух ёстой салшгүй холбоотой. Гэвч эрт цагаас инагш овгийн ахлагч, удирдан манлайлагч, алив эрдэм заан сургагч тэргүүнүүдээ заан сонгож ирсэн нандин уламжлалаас ундраатай буюу. Хэрэвзээ ихэс дээдэс, эрхэм багшаа хүндлэн дээдлэх заншилгүй, хоосон цэцэрхэгсэд байсан аваас үнэнч нөхөртөө сүү мэт цагаан, өстөн дайсандаа арслан барс мэт догшин, морин дэл дээрээсээ ирээдүйн иргэншлийн гэрэл гэгээг асаасан нүүдэлчин Монголын ард түмэн бид "лам" нарыг "лам багш"-аа хэмээн нэрлэж байсан нь багшийг ихэд эрхэмлэн үзсэний хөдөлшгүй баримт болой.

Монголын болон дэлхийн түүхийн тавцанг эзэгнэнхэн төрсөн бидний өвөг хаадууд өөрийн засаглалаа тогтоохдоо өрнө дорны орнуудаас эрдэмтэн чадвартан, уран дархчуулыг урин залж, ард иргэддээ соёл урлаг, ахуйн иргэншлийн хэв ёсыг түгээн сургаж байсан болно. Үүний жишээ бол тэнгэрийн доорхид оюун ухаан, эрдэм чадвараараа хэтийдсэн Ифтихар Ад Диныг нийслэл Хар хорум хотноо урин залж, их эрдэмийн хөлгүй далайгаар нь аялж байжээ. Дээр өгүүлсэнээс үзвэл эртний хаад ноёд эрдэм чадвар дулимаг байж уу хэмээн үзвэл эндүүрэл болно. Тухайлбал, эзэн богд Чингис хаан цэрэг дайны гарамгай чадвартан байснаас гадна хүмүүнийг сонгон хэрэглэх талаар даяар олонд эгнэшгүй мэргэн бодлоготой билээ. Мөн түүний ач Мөнх хаан дөрвөн орны хэл нэвтэрхий мэддэг байсанаас гадна хууль цааз, төр барих эрдэмд гарамгай Шихихутаг, Елюй Чуцай, Уйгардай, Тататунгаа болон Мухулай, Зэв, Субээдэй зэрэг цэрэг дайны хэтийдсэн мэргэд их хаадын дотны зөвлөх, багш нар нь байсан билээ.

Монголчууд эртнээс үр хүүхдүүддээ нүүдэлчдийн ахуйн ёсонд сургаж байжээ. Үүнд эсгий хийх, хонь мал хариулах, нүүдэл суудал хийх, түүнд тохирсон газар орон цаг хугацааг сонгох аж амьдралын наад шатны ухаанд дадлагажуулан сургаж иржээ. Чингэхдээ бидний өвөг дээдэс чиний миний хэмээн хоточ ноход мэт үл хагаралдан нийтдээ заан сургадаг нэгдмэл арга барилтай сурган хүмүүжүүлэгчид байсан юм.

Нүүдэлчин Монголчууд хүүхдээ хүмүүжүүлэхдээ дараах хэдэн зүйлийг ихэд эрхэмлэн ирэв. Тодруулбал:

Хүнийг хайрлан, хүндэтгэх ёсон

Аж төрөхүйн энгийн ухаан

Цэрэг дайны эрдэм чадвар

Гал голомт, газар эхээ шүтэх

Бичиг эрдэмд түрэмгий сургах /10/-д үлэмж анхаарч байжээ.

Тэдний хүү /охин/ хүмүүжилгүй, дуулгаваргүй, арчаагүй, ааштай гэх зэргээр өөрийн эцэг эх болон өвөг дээдсээ муумлуулах нь есөн булгийн доор

өнөд норссон ч үл хоцрох мөнхийн ичгүүрт ёс юм. Чингэж өөрийн буюу эцэг өвгөдийнхөө нэр нүүрийг түмэн үедээ гэгээн ариун байлгах үзэл санаа нь *багш шавийн барилдлагааг* шүтэн барилдуулж буй нэгэн чухал үндэс болдог. Шавиа сургахдаа зодох, занчих арга барил ардын уламжлалт сургалтанд дээдийн дээд харш зүйл ажээ. Харин дарангуйлан сургах арга барил нь нилээд хойно үед холбогдох буюу. Хүмүүнийг ацаг шүдийг таних үндэсийг соёолуулахаас эхлээд алдар цуут мэргэдийг сурган боловсруулсан хүтэл их хэргийг оюунаа оргилуулж, эрдэм чадвараа ирлэн байж гүйцэтгэгч нь хүн төрөлхтөнд тодорхой болой. Иймийн тул багш, шавийн байр суурийг тодорхойлон тэдний барилдлагат ёсыг зарчим болгон уламжлан ирсэн. явдал бол тухайн цаг үеийн боловсролын ололт амжилтын тоонд зүй ёсоор багтах учиртай бөлгөө.

Олон үндэстэн ястанг нэгтгэсэн Их Монгол болон Их Юань гүрний үед цэргийн дотор багш шавь, цэрэг дарга зэрэг холбоо зузаан хөгжсөн байжээ. Цэргийн гарамгай жанжууд, түмт, мянгат, зуут, аравтын дарга нар багачуул хүүхдүүийг бага наснаас нь харь газар нутгаар дагуулан явж, хорвоогийн түмэн учир буман шалтгааны тайлбарлан таниулах, ахас ихэсээ хүндлэх ёсыг хэвшүүлэн сургах, цэргийн эрдэм, нум сум харвах, ан ав зэрэгт дадлагажуулан заадагаасгадна хатуужил тэвчээр эх оронч хүмүүжлийг давхар олгож ирсэн баялаг уламжлалтай билээ бид.

Түвэдийн бичгийн их хүмүүн Зонхова /1359-1419/-ын боловсруулсан багш, шавийн барилдлагат ёсны эхэнд буяны саданг шүтэх ёс орно. Тэрбээр багш хүний эрхэм зорилгыг тодорхойлохдоо: *"шавь нарыг эрдэм номтой, энэрэнгүй, хүмүүнлэг үзэлтэй шашин номын ёсыг хүндэтгэдэг түүнийг хэрэгжүүлэх аргатай ариун бодь сэтгэлтэй болгоход оршино"* /11/ хэмээн номлосон буй.

Зонхова богдын зохиосон *"Бодь мөрийн зэрэг"* зохиолд Шавийн тав, Багшийн арван эрдэмийн тухай өгүүлдэг хэдий ч шавийг зодож сургах талаар огт тэмдэглээгүй байна. Багшийн арван эрдэмийг гаргахдаа:

Номхотгох

Амирлангуй

Чухал амирлангуй

Иш /онол/-ээр баялаг

Хоосон чанарыг оносон

Эрдэмээр үлэмж

Өгүүлэхүйд мэргэн

Энэрэнгүй

Хичээнгүй

Уйтгарыг тэвчихүй эдгээр болно. Дээрхи арван билэг чадвар

болбоос бурханы шашны ёсонд боловсролын эрхийн үндсийн үндэс болдог нь тодорхой байна.

Эртний түүхийн шаргал хуудсыг нягтлан үзвэл, өөрийгөө ариусгахын үндэс болсон тэвчээр багш, шавь хоёрын хэн хэнд нь нэн чухал байжээ. Мөн эрдэмд шүтэгч шавийн билэг чанар ч багтана. Энэтхэгийн мэргэн номч Арьяандива *"Дөрвөн зуутын үвдис"* зохиолдоо: *"Шударга оршигч буюу өөрийнихүслээр багшид бишрэгч, төгс оюуют буюу номлолын мөрийн сайн-мууг ялган чадагч, тусгайлан эгээрэгч буюу утгыг мэдэгч гурав бол билэг чанарыг эзэмших сав мөн"* /12/ хэмээн шүтэгч шавийн билэг оюуныг дурьсан ажээ.

XIX зууны Монголын нэрт соён гэгээрүүлэгч Говийн догшин хутагт Данзанравжаа /1803-1856/ бээр *"Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу"* хэмээх сургаалийн шүлэгтээ багшийн талаар өгүүлэхдээ:

"Зоргоор бус үнэнээр бол сургаж болно

Зориуд бус халамжлах сэтгэлээр бол сургаж болно

Зовлонт үйлээс зайлуулагч бол сургаж болно" хэмээжээ.

Чингэж бичсэн нь багш хэмээгч нь чин үнэнч сэтгэл эргэлтгүй, халамжит сэтгэлийг нарны цацраг болгож, шавийн сэтгэлийг эрдмийн хөлгүй далай дахь завьны сэлүүрч хүмүүн болохыг Монгол хэлний арвин баялагаар уран тансаг өгүүлсэн буй.

Эрт, эдүгээгийн дорнын сод мэргэдийн бүтээлүүдэд өгүүлсэнээр хүмүүний оюуны сайжрал нь *таван замыг* туулан өггөрдөг хэмээнэ. Тэдгээр таван зам болбоос,

Нэгд, Сайн үрийг цуглуулаад сонсоод байна.

Хоёрт, Сонсож, цуглуулсанаа үйл ажиллагаатайгаа хослуулах

Гуравт, Шат болгонд үр дүн хэрхэн явагдаж буйг тодорхойлох

Дөрөвт, Өөрийн сонсож, цуглуулсан мэдлэгтээ итгэл үнэмшилтэй болно

Таад, Үл хуурагдах мөрийг олж, хөндлөнгийн ямарч саадыг бут ниргэх мэдлэгийн хүч аажимдаа улам нэмэгдэн хуримтлагдсаар байна. Эдгээрийг туулж өнгөрсний дараагаар л хүн гэгч сая оюуны манлайг олж, гүн бат мэдлэг эзэмшиж чадна гэж сургажээ.

Орчин үеийн багшийн хэв шинж, ёс суртахуун:

Ахмад үеэ хүндэтгэх үзэл санаа нь Багшийг хүндэтгэх үзэл санааны үндэс суурь нь болж өгдөг. Багшийн гавъяа бол шавийн билэг оюун хэтийдэн бирд номтоныг мохоон унагах бяр сууж, цаашдаа тэнгэрийн доорх түмэн олныг гэрэлтүүлэн гийгүүлэх, уран шийдэмгий арга барилтай нэн хариуцлагатай үйлсийг бүтээсний сүр жавхлант ялалт юм.

Багш хүмүүн дээдсийн болон ахмад үеийнхээ сурган хүмүүжүүлэх арга барилыг гарамгай өвлөн авч тухайн цаг үеийнхээ туршлага дээр үндэслэн шинэчлэн баяжуулж, ухуулан сургах, хайрлах, итгэн дагуулах, авъяаслаг, уран илтгэгч, цуцалтгүй хөдөлмөрлөгч байх ёстой хэмээн үздэг. Мөн үнэнч даруу, шавиа хүндэтгэдэг, нөхөрсөг, нинжин сэтгэл, эрдэм мэдлэгтэй боловсрол түгээгч манлай байх нь багшийн дээдийн дээд эрхэм чанар юм.

Багш хүмүүн биеэрээ үлгэрлэдэг, сурагчидтайгаа зөв боловсон харьцдаг байх, цаг ямагт өөрийн оюун ухаанаа хурцалж, хөөрч дэвэртэл зоригжуулж, хөлс чийхартал зэмлэдэг, сэнхрүүлдэг мэргэн бодлоготой, улс орныхоо дотоод гадаад амьдралыг сайтар мэдсэн, ер нь аливаа бүх үйлсээрээ хошуучлагч байж хойч үе болсон шавь нартаа бахархах омгорхох сэтгэлийн ухаарал хайрладаг байх чухалтай байна.

Залуу хойч үеэ амьдрал-хөдөлмөрийн амтанд амлуулах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцож, түүнийхээ ач холбогдолыг ухааран бясалгадаг шударга иргэнг эх орондоо хүмүүжүүлэн өгөх ариун үүрэгтэй. Чингэхдээ харилцан итгэх итгэлцэх харилцааг дээдэлж, элдэв доромжлол гутаах үйл ажиллагааг цаг ямагт үндсээр нь таслан зогсоож, сурагчидтай зүй бус харьцах, хилс үнэлэхийг нэн цээрлэх шаардлагатай буюу.

Мэдлэг болвсролыг түгээх нэн чухал үүрэгт сурган хүмүүжүүлэх эв дүй зайлшгүй холбогдоно. Учир нь тус асуудал багшийн мэргэжилийн чадварыг ариутган шүүх гол үндэслэл, хэр зэрэг багш хүн болохыг тодорхойлох гол хэрэгслэл болдог байна. Нийгмийн сэтгэл зүйн үзэгдэл, түүнд бие хүний гүйцэтгэх хүмүүнлэг энэрэнгүй үзлийн шинж чанараас багшийн эв дүй түүний нийгмийн чанар урган төлждөг байна. Багшийн сурган хүмүүжүүлэх эв дүй нь сурагчид /оюутан/-ийн ёс суртахуун, сэтгэл зүйн дүр төрхөөр тодорхойлогдоно.

Багш бээр шавийн үйлдэлд үнэн зөв үнэлэлт өгч, шударга шаардлаг, мэдлэгтэй зэрэг үйлдлийн цэгц үнэлгээнээс багшийн шударга байдал төлжин соёлдог байна. Тухайлбал, сурагчдын хариултыг үнэлэхдээ авъяас билэгийг нь харгалзах, өөртэйгээ ажилладаггүй сурагч хөнгөн мэдлэгтэй байдаг болон тэчээртэй сууж хөдөлмөрлөдөг сурагчийн мэдлэг бат бэх байдаг зэргээр үнэлэлтийг тодорхойлох нь шударга байдалд үл нийцнэ.

Багш хүмүүнд заяагдсан нэр хүнд нь нийгмээс хүлээн зөвшөөрөгдсөн багшийн ёс суртахууны эрхэм чанарын үндсэн дээр хүн хүндээ болон хамт олондоо нөлөөлөх уур амьсгал юм. Багшийн нэр хүнд нь мэргэжил нэгт нөхөд, сурагчдынхаа өмнө хүлээсэн ёс зүйн байр суурь, хөдөлмөр, үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаална.

Багшийн мэргэжил бол нийгэмд хамгийн ойр мэргэжил ёс суртахууны чанарыг их шаарддаг "Хүн төрлөхтний төлөө бүхнээс илүү хөдөлмөрлөх ёстой. Тийм мэргэжлийг бид сонгосон болохоор түүний хүнд хүчир дарамтын дор өвдөг сөхрөхгүй учир нь энэ бол бүх нийтийн төлөө бүхнээс илүү хөдөлмөрлөх ёстой. Тийм мэргэжилийг бид сонгосон болохоор түүний хүнд хүчир дарамтын дор өвдөг сөхрөхгүй, учир нь энэ бол бүх нийтийн төлөө бидний өргөх өглөг барьц мөн" / 13 / хэмээн К.Маркс өгүүлсэн байдаг байна.

Эдгээр уянгалаг үгс нь багш хүний мэргэжилийн шинж чанарыг тодорхойлж байна. Багшийн ёс суртахууны үйл ажиллагаа нь шавь нарын хүмүүжлээр хэмжигдэх ёстой. Сургуулийн хүрээнд зохиогдож байгаа ёс зүйн хүмүүжил нь багшийн зорилготой үйл ажиллагаа, гэр бүлийн болон хамт олны үйл ажиллагаатай шүтэн барилдсанаар илэрдэг.

Шавь нартаа "улс төр-ёс зүйн-хөдөлмөрийн" гэх пирамид хэлбэрийн хүмүүжлийн ажлийг зохиох аваас аливаа үр дүн нэн хүртээмжтэй. Багш бээр шавь нартаа ёс суртахууны мэдлэг олгохдоо доорхи дөрвөн зүйлийг баримтлах чухалтай байна. Үүнд: *Нэгд*, өөрийгөө байнга судлах. *Хоёрт*, "өөр больё" гэсэн зорилготойгоор ажиллах. *Гуравт*, бусад хүмүүстэй өөрийгөө байнга харьцуулж байх. *Дөрөвт*, үйл ажиллагаа ба харилцааны явцад судлахаас ямарч нөхцөлд өөрийгөө болон бусдыг болохыг анхааран үзэх. *Тавд*, хүнийг болон өөрийгөө судлах нь зарчмын хувьд төгсгөлгүй байдгийг анхааран үзэх, эдгээр зарчмыг багш өөртөө цаг ямагт мөрдлөг болгож байж чадваас сая хүүхдэд ёс зүйн хүмүүжил олгох бэлтгэл хангагдана. *Зургаа*, Ёс суртахууны ухамсар, мэдрэмж, зан үйлийн өв тэгш хослол бол багш хүний шавь нараа төлөвшүүлэхээр эрмэлзэж байдаг ёс суртахууны туйлын эрхэм зорилго болно.

Багш, шавийн харилцааны хэм хэмжээ:

Дээр өгүүлсэн асуудалд юуны урьд багш шавь хоёр нь харилцан бие биенээ ойлгодог, хүндэтгэн итгэлцдэг, эвсэг нөхөрсөг, санал бодлоо бие биендээ чөлөөтэй илэрхийлдэг, өөрийгөө шүүмжлэхэд дургүйцдэггүй байх ёстой. Мөн түүнчлэн эв нэгдэл, нинжин сэтгэл, үнэнч өгөөмөр зан цалгин байхаас гадна багш бээр нүдэнд харагдаж, чихэнд сонсогдохуйц үлгэр жишээч, сурагчидтай нягт барилдлагатай байж чадваас сая шавь нартаа хүндлэгдэх бидний дунд үе улиран ирсэн бичигдээгүй аман хууль буй.

Монголчуудын эртний зан үйлд багш хүний эрхэм чанар, соёл хүмүүжил, эрдэм мэдлэгийн далайг бишэрсээр ирсэн билээ. Өмнө дурьдсанчлан Зонхова богд "*Бодь мөрийн зэрэг*" зохиолдоо уг асуудлын талаар өөрийн сургаалаа ширгээн өгсөн нь өдөгөө бидний цагт сурган хүмүүжүүлэгч хүний эзэмшсэн байвал зохих зан төлөвтэй тана сувд адил тохирч байгаа юм. Шавь хүний жигшин цээрлэвэл зохилтой зүйлийг савтай зүйрлэн тун ч ончтой сургажээ. Үүнд: 1. Ёроол нь цоорхой сав, 2. Дотроо хир буртагтай сав, 3. Ам нь хэмхэрхий сав гэж жишин сургасан буй.

Нэгэн ижийн хэвлийд зулай зулайгаа даган төрөөгүй атлаа төрсөн эцэг эх, ах дүү, элгэн садан адил бие биедээ чүн сэтгэл, итгэл журамаар нөхөрлөн ханьсах явдалыг *ах дүүгийн барилдлага* хэмээн тодорхойлдог. Үүүнтэй адил бүх шавь нар хоорондоо ба багшдаа төрсөн ах дүү, эцэг эх адил элэгсэг дотно, үнэнч шударга, эрхэм сайн байх ёсноос "*барилдлага*" гэсэн санаа урган гарсан байна.

Шавь бээр учир барилдсан багшийнхаа нэрийг ч хэлэх цээртэй байжээ. Шавь хүн багшийнхаа өмнө зүүн гарынхаа алгыг баруун гарынраа алган доор

тавин сөгдөн сууж эрдэм сургаалийн охь шимээс дээжлэн авдаг байсан нь багшийг эрхэмлэн санаж хүндэтгэх байсанаас гадна заалгаж буй номоо сүсэглэн дээдэлж байгаагийн илрэл байжээ. Ийнхүү шавь бээр хураан буй эрдэмийн хурд машид сэтгэл ханамжтай, хичээнгүй биширсэн, идэвхизүтгэл үлэмж, саад бэрхшээлд шантралгүй хүсэл эрмэлзлэлтэй байх нь нэгэн сэтгэлээр эрдэм сурах үндсийн үндэс болой.

Эртнээс өнөөг хүртэл багш нар өөрийн гарын шавь нартай байжээ. " ... Эцэг эх багш тэргүүтэн ачтаны төлөөлөлийн ачийг эрх биш хариу лан бодож тусыг ихэтгэх эзэн дээдийн албанд гавъяа зүтгэлээ хичээ.Эх болсон хамаг амьтаныг энэр.

... эелдэг зөөлөн зан зангаас, этгээд гажуу сэтгэлийг эгнэгт тэвчин цээрлэ.

... эс мэдсэнээс битгий мэдэнгүйрэх, эрдэм сурахыг үйлдэвч уйдалгүй авъяас шавь.

Эрдэмтэй боловч омгорхох хэрэггүй

Эргүү тэнэг болбоос өөрийн хирийг мэдэж авбаас сайн

...Эрдэмтэй болоод, эвтэй болбоос нэн сайн ..." гэх зэргээр шавь нарын эзэмшсэн байваас зохих, номхон дөлгөөн аясыг ноён хутагт Данзанравжаа "Орчлогийн алтан товч" зохиолдоо шавь хүний таван эрдэмд тулгуурлан бичжээ.

Abstract: Mongolia's traditions have deep respect for pupils and teachers. The reputation of a teacher should always be high, as it is the source of evaluation of a certain people's social, political and ideological standards.

Ном зүй

1. Монгол улсын түүх (эрхэлсэн Ж.Болдбаатар) УБ., 1999.т. 324.
2. Мөн тэнд.т.323.
3. Г.Сүхбаатар. Сяньби.УБ.,1972.т.121.
4. Мөн тэнд.т.121.
5. БНМАУ-ын түүх. Тэргүүн дэвтэр . УБ., 1966.т.130-146.
6. Мөн тэнд.т.161.
7. Мэргэн гэгээний Алтан товч. Хөх хот., 1994.т.50.
8. Ч.Далай. Монголын түүх. Юань улс (1260-1368).УБ.,1994.т.157.
9. Мөн тэнд .т. 158.
10. Б.Бадамсэрээжид.Ардын уламжлал ба багш шавийн барилдлага.
(Ардын сурган хүмүүжүүлэх өвөөс) УБ., 1991.т.48.
11. Г.Эрдэнэ-Очир. Хүнээр хүн хийх Монгол ухаан.УБ., 1991.т.141.
12. Мөн тэнд .т.143.
13. Б.Бадамсэрээжид.Ардын уламжлал ба багш шавийн барилдлага
(Ардын сурган хүмүүжүүлэх өвөөс) УБ., 1991.т. 51